

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших “Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр”-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



ГАРЧИГ

1. ОРШИЛ.....	4
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	5
1.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт.....	7
1.3. Хүдэр баяжуулах технологийн сонголт.....	7
1.4. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим.....	8
1.5. Хаягдлын овоолго.....	8
1.6. Дэд бүтэц.....	9
1.6.1 Цахилгаан хангамж.....	10
1.6.2 Усан хангамж.....	10
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	11
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ашиглалт.....	18
4.2 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	22
4.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
4.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	23
4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	24
4.7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
4.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
4.9 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.....	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицол	5
Хүснэгт 2. Технологийн ерөнхий шийдлүүд	8
Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим	8
Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ	9
Хүснэгт 5. Үйлдвэрийн газар ашиглалтын төлөвлөлт	9
Хүснэгт 6. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	11
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр	14
Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл	17
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 10. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	6
Зураг 2. Төслийн талбайн байршлын агаар, сансрын зураг	6
Зураг 3. Баяжуулах үйлдвэр	10

1. ОРШИЛ

“Арвижих хүдэр” ХХК нь өндөр чанартай төмрийн хүдрийн баяжмалыг гадаадын зах зээлд нийлүүлэх, замаар улмаар бүс нутгийн төмрийн хүдрийг боловсруулж дотоод гадаадын хэрэглэгчид нийлүүлэх зорилгоор энэхүү баяжуулах үйлдвэрийг барьж компанийн бизнесийн бодлогоо тодорхойлж байна.

Тус үйлдвэр нь Хэнтий аймгийн Дархан суманд, сумын төвөөс баруун урагш 35 км орчим, Бор-Өндөр сумаас баруун хойж 20 км зайд байрлана. Монгол орны 1:100000 хэмжээсийн номнклатуриар L-49-60 хавтгайд хамаардаг.

Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр нь жилд 300 мян, тн хүдэр боловсруулж 142,4 мян,тн баяжмал гаргана. Баяжмал дах төмрийн хүдрийн агуулга 51%-иас дээш, металл авалт нь 8-85% байна.

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилан баяжуулах хэсэг, баяжмал хадгалах талбай, засвар үйлчилгээний хэсэг, цахилгаан хангамжын хэсэг, ажилчдын байр, контор зэргээс бүрдэнэ.

Шигшилтээс гарах 15мм, 15-25мм-ийн ширхэгтэй хүдрийг тус тусд нь STL-0818 маркийн хуурай соронзон сепратороор баяжуулан эцсийн баяжмал болон хаягдал бүтээгдэхүүн гарна. Хоёр сепратороос гарах хаягдлыг нийлүүлэн VTL-0818 маркийн нэг шатны хяналтын хуурай соронзон сепратороор баяжуулан завсрын бүтээгдэхүүн болон хаягдал хүдэр гарна.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал нь 500.0 мян.тн бөгөөд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 80-90%-тай ашиглах үед баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 96.2 тн байна.

Төслийн талбай нь ус зүйн хувьд Азын гадагш урсгалтай ай сав, Умард говийн гүвээт-Халхын говийн сав газарт тус тус багтана. Тус сум нь гадаргын усан хангамжаар муу, ихэвчлэн газрын гүний ус ашигладаг.Төслийн талбайн районд гадаргын ил урсац байхгүй харин унд ахуйн хэрэгцээнд хоногт 0,6м³-ын өөрийн худгийг ашигладаг болно.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нээж, байгууллагын нэр:

- “Арвижих хүдэр” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар:
 - Регистрийн дугаар: 6073549

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Рокмон бюлдинг -800 тоот.
 - Утас: 976-99100759,
 - Мэйл хаяг: arvijikhuder@gmail.com

Төслийн хүчин чадал

- Тус баяжуулах үйлдвэр нь жилд 500000 тонн хүдэр боловсруулан баяжуулах бөгөөд жилд 300 хоног ажиллана.


Төслийн байршил:

“Арвижих хүдэр” ХХК ийн Баргилт Овоогийн төмрийн хүдрийн ордыг түшиглэн байгуулах хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт хамаарах ба Улаанбаатар хотоос 300 км т, Хэнтий аймгийн Дархан сумаас баруун урагш 35 км орчим, Бор Өндөр сумаас баруун хойш 20 км зайд байрлана.


- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49–60
- Талбайн хэмжээ: 15 га

Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	109	16	4.99	46	19	1.05
2	109	16	4.42	46	19	19.19
3	109	16	15.17	46	19	19.4
4	109	16	15.17	46	19	9.1
5	109	16	19.93	46	19	9.1
6	109	16	20.18	46	19	1.28



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Зураг 2. Төслийн талбайн байршлын агаар, сансрын зураг

1.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

Физик газарзүй:

Тус газрын уулс нь д.т.д 1050-1700 м өргөгдсөн, баруун хойноос зүүн урагшаа сунан тогтсон үндсэндээ хоёр нуруу нэг уул хоорондын хотгороос тогтоно. Ордын талбайн баруун хэсэг нь Онон голын хөндий Батширээтийн хотгорын зүүн хананд тулна. Батширээтийн хотгор нь д.т.д 1100 м-ээс 1200 м өргөгдсөн Ононгийн хөндийг дагаж хойноос урагшаа чиглэлтэй сунан тогтсон ухаа толгодлог, тэгш талархаг 10 км орчим хөндий юм.

Уур амьсгал:

Баргилт-Овоогийн төмрийн ордыг түшиглэн байгуулах хуурай соронзон аргаар б аяжуулах үйлдвэр орчмын нутаг дэвсгэрийн нарны цацаргийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн 4-н улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байна.

Хөрсөн бүрхэвч:

Төслийн талбайн Монгол орны хөрс-газар зүйн мужлалаар Хангайн их муж, хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор-Өндөр-Уул буяны тойрогт хамаарагдана. Төслийн талбайн районд толгодын нимгэн сайр чулуурхаг хүрэн хөрс тархана. Энэхүү хөрс нь далайн түвшинээс дээш 1481-1501м-ийн өндөрт байрласан нам уулс толгод, тэгш талд тогтворжсон байна. Гадаргын налуу хэвгий нь 0.83-5.3 градус байна.

Ургамлан нөмрөг:

Ургамал -газар зүйн мужлалаар А.А.Юнатовын үйлдсэн ботаник газарзүйн мужлалаар Евро-Азын хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Дундад Халхын хээрийн тойрогт хамаарна. Тухайн тойрог ухаа гүвээт толгод бүхий тэгш талын төрхтэй. Тэнд хээрийн ургамалжилт зонхилж хотос хонхор газраар нь дэрс бүхий давссаг /галофит/ ургамалд бүлгэмдэл элбэг тааралдана. Бор-Өндөр орчмын нутаг гол төлөв хээрийн хэв шинжийн ургамалжилт зонхилох бөгөөд хэд хэдэн дэд хэв шинжид ангилагдана.

Нийгэм:

Энэ нутагт халх ястан голлон амьдрана. Хүн амын нягтшил багатай, Дархан сум нь 1956 оны 8сарын 1нд Ардын хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянмөнх сумтай нийлж, 1957 оны 8-р сарын 1-нд дахин бие даасан сум болон байгуулагджээ. Одоо Дархан сум нь засаг захиргааны 5н багтай, 2000 гаруй хүн амтай. 189759 толгой малтай байна.

1.3. Хүдэр баяжуулах технологийн сонголт

“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-т хяналт сорьцлолтын ажил хийлгэж шинжлүүлэн гарсан үр дүн, баяжуулах үйлдвэрийн ажилласан хугацаан дахь технологийн горим, үзүүлэлтүүд зэрэгт тулгуурлан баяжуулах технологийг сонгон доор дурдсан технологийн ерөнхий шийдлүүдийг гаргасан.

Хүснэгт 2. Технологийн ерөнхий шийдлүүд

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	500 мян.тн/жил 1 852.0 тн/хоног 92.6 тн/цаг 300 хоног/жил 6 480 цаг/жил
Анхдагч хүдэр дэх төмрийн агуулга	32 %
Баяжуулах технологи	Хуурай соронзон баяжуулалт
Хүдэр бэлтгэх технологи /бутлалтын зэргээр/	3 шатны бутлалт 1 шатны шигшилт
Хүдэр баяжуулах технологи /шат дамжлагаар/	Үндсэн-1 Хяналт -1
Хаягдлын хэлбэр	Бүхэллэг хуурай

1.4. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг жилд 500.0 мян.тн байхаар, тоног төхөөрөмжийн ашиглалт 80-90.0 %-тай байхаар тогтооход үйлдвэрийн цагийн хүчин чадал 92.5 тн байна. Баяжуулах үйлдвэр өвлийн хүйтний улиралд зогсож, 2-р сарын 25-ээс 12-р сарын 25 хүртэл 300 хоног ажиллахаар төлөвлөсөн. Нийт ажиллах хоногоос баяр ёслол, цаг агаарын хүндрэл болон засвар үйлчилгээ гээд нийт 30 хоног төлөвлөж, бодитоор 270 хоног ажиллана

Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

№	Ажиллах горим	Хэмжих нэгж	Тоон хэмжээ
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	10
3	Цаг агаарын хүндрэл	хоног	10
4	Засвар үйлчилгээ	хоног	10
5	Өвлийн улирлын зогсолт	хоног	95
6	Жилд ажиллах нийт хоног	хоног	300
7	Жилд ажиллах бодит хоног	хоног	270
8	Жилд ажиллах цаг	цаг	6'250
9	Хоногт ажиллах цаг	цаг	24
10	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
11	Ээлжид ажиллах цаг	цаг	12
12	Техникийн ажлын норм	%	83.33
13	Цагийн хүчин чадал	тн/цаг	92.6
14	Хоногийн хүчин чадал	тн/хон	1'852.0
15	Жилийн хүчин чадал	тн/жил	500'000.0

1.5. Хаягдлын овоолго

Баяжуулах үйлдвэрээс -25 мм-ийн ширхэглэлтэй 9 %-ийн төмрийн агуулгатай 175.5 мян.тн хуурай хаягдал гарна. Баяжуулах үйлдвэрээс гарч буй хаягдал дахь төмрийн агуулга бага, Үүнээс баяжуулах үйлдвэрийн гадаад тээврийн замын арчилгаа болон бусад орон нутгийн замын арчилгаанд 10.0-20.0 мян.тн хаягдал хүдэр хэрэглэхээр тооцоход жилд хаягдлын овоолгод байршуулах хаягдлын хэмжээ 130.0-140.0 мян.тн /35.0 мян.м³/ байна.

Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	Нийт
1	Баяжуулах хүдрийн хэмжээ	мян.тн	500.0	500.0	500.0	500.0	500.0	2500.0
2	Үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ	мян.тн	175.5	175.5	175.5	175.5	175.5	877.4
3	Хаягдалд агуулагдах төмрийн агуулга	%	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
4	Хаягдал дахь төмрийн хэмжээ	мян.тн	15.8	15.8	15.8	15.8	15.8	79.2
5	Зам засварын ажилд хэрэглэх хаягдлын хэмжээ	мян.тн	40	40	40	40	40	200.0
6	Овоолгод байршуулах хаягдлын хэмжээ	мян.тн	135.5	135.5	135.5	135.5	135.5	677.4
		мян.м³	32.3	32.3	32.3	32.3	32.3	161.3

Хаягдлын овоолгыг өөрийн эзэмшлийн талбайд, баяжуулах үйлдвэрийн урд талд 50-100 м зайд 100х170.0 м хэмжээтэй газар байгуулахаар төлөвлөсөн. Хүдэр баяжуулах үйлдвэрийн хаягдлын овоолго доорх нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Үйлдвэр ажиллах хугацаанд гарах хаягдлыг багтаах хангалттай багтаамжтай байх
- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл бага байх
- Үйлдвэрлэлийн үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- Бүтээгдэхүүн тээвэрлэх зардал хямд байх
- Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг тээвэрлэж хаях аргыг сонгохдоо хаягдлын хэмжээ, шинж чанар, хаягдлын овоолго хийх талбайн хаялбар, баяжуулах үйлдвэрээс хаягдлын овоолго хүртэлх зай зэрэг үзүүлэлтүүдээс хамаарч сонгоно. Баяжуулах үйлдвэрийн хаягдлын овоолгод тоосжилт үүсэхээс сэргийлж овоолгын налууг өдөр бүр услахаар төлөвлөсөн.

1.6. Дэд бүтэц

Баяжуулах үйлдвэр нь тус бүс нутагт орших Баргилт-Овоогийн төмрийн хүдрийн ордоос балансын хүдэр худалдан авч хуурай соронзон аргаар баяжуулан, экспортын шаардлага хангасан баяжмал үйлдвэрлэнэ. Баяжуулах үйлдвэр нь дараах нэгж хэсгүүдээс бүрдэнэ.

- Анхдагч хүдэр буулгах талбай
- Бутлан ангилах, баяжуулах хэсэг
- Баяжмал, хаягдлын овоолго
- Авто пүүний хэсэг
- Цахилгаан хангамжийн хэсэг
- Захиргаа, ажилчдын байр
- Засвар, сэлбэгийн газар
- Баяжуулах үйлдвэр орчмын замууд зэрэг объектууд багтана.

Хүснэгт 5. Үйлдвэрийн газар ашиглалтын төлөвлөлт

№	Эдэлбэр газар нэр	Талбай /га/
1	Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж	0.14
2	Ажилчдын байр	0.71
3	Зам	0.24
4	Овоолго	
Нийт		11.03



Зураг 3.Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэрийн ажиллагсдын байр болон үйлдвэрийн захиргаа зэргийг эзэмшил газрын баруун урд талд контейнер хаусан байшин, монгол гэрүүдийг барьсан. Ажиллагсдын тосгон, үйлдвэрийн захиргаа нь баяжуулах үйлдвэрээс 300 орчим метр зайтай байна. Энд захиргааны ажилтнуудын контороос гадна хоолны газар, халуун ус, амрах байр, амралтын өрөө, сургалтын өрөө, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө зэрэг байна.

Баяжуулах үйлдвэр дээр нэг ээлжид ажиллах ажилчдын тоо 30-35, ИТА-ын тоо 6-7, оператор болон туслах ажилчдын тоо 20-23 хүн ажиллах тул ажиллах хүчний тоо болон дэд бүтцийн байршлаас хамааран хамгийн ойр байрлах Бор-Өндөр сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх, шаардлагатай бол баяжуулах үйлдвэр дээр гэрээт эмч, сувилагч ажиллана.

1.6.1 Цахилгаан хангамж

Тус баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Улаанбаатар-Багануур-Чойр-Бор-Өндөр хүртэл татсан 110кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар ирж буй өндөр хүчдэл нь Бор-Өндөр сум дээр 35 кВ-ын өндөр хүчдэл болж буурах тул Бор-Өндөрөөс Баргилт овоогийн уурхай хүртэл татсан 35 кВ-ын шугам татаж, уурхайн дэргэдэх 35/6 кВ-ын ерөнхий бууруулах дэд станцаас 1.5 км зайд 6 кВ-ын агаарын шугам татаж баяжуулах үйлдвэрийн дэргэд 6/0.4 кВ-ын трансформаторын дэд станцыг 2017 онд барьж байгуулан цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

1.6.2 Усан хангамж

Хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах тул үйлдвэрийн технологид ус хэрэглэхгүй. Үйлдвэрийн эзэмшлийн талбайд гүний худаг өрөмдөж гаргсан ба ажилчдын унд, ахуйн зориулалтаар ашиглах ус, ногоон байгууламж услах ус, замын тоос дарах усыг өөрийн гүний худгаас хангана.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт “Арвижих хүдэр” ХХК төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлох, тоо хэмжээг тооцохдоо БОНХЯ-ны сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тушаалаар батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалд тусгагдсан арга, аргачлалыг ашиглав.

3.1. Боломжит нөлөөллийн тодорхойлолт

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын хэвлий, газрын гадарга, агаар, хөрс, ургамал, амьтан юм.

Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 6. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа		Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт	х			х			х		х	
Гадаргын урсцын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х			х			х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х			х			х		х	
Геологийн тогтцын өөрчлөлт	х			х			х			х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		х		х		х				х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х	х		х				х
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	х			х		х			х	
Бэлчээрийн байдал	х			х			х			х
Эрдэс түүхий эдийн нөөц	х			х			х		х	
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар,	х			х						

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа		Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
хэмжээ										
Гадаргын усны чанар хэмжээ										
Агаарын бохирдол	x			x		x			x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x			x			x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x		x				x
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x			x			x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x			x			x			x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x			x			x		x	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x		x		x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	x			x			x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x			x			x
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	x			x			x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x			x			x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			x			x		x	
Ажлын байр нэмэгдэх	x			x			x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x			x		x	
7. Бусад нөлөөлөл										
Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	x			x			x	x		
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x			x		x	
Бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорхи усыг бохирдуулах		x		x			x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал, зайлуулалд муугаас эвгүй үнэр гарч, шавж үржих	x			x		x				x
Дүн, 110	23	4	1	28	0	7	20	1	15	11

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 23 (66%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Үйл ажиллагааны явцад ус, хөрс, ургамал, амьтан, геологийн тогтоц, газрын гадарга, бэлчээр, байгалийн дүр төрхөд, орчны бохирдол зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх муу талтай байна. Харин орон нутгийн нийгэм-эдийн засагт шууд эергээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл

Нийт нөлөөллийн 4 (11%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Гүний усны чанар, хэмжээ, хүн амын эрүүл мэндэд шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эергээр нөлөөлөхөөр байна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь богино хугацааны нөлөөлөлд 28 (80%) нь хамаарагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

Нөлөөллийн чиглэл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт нөлөөлөл үзүүлж болзошгүй нийт нөлөөллийн 20 (57%) нь буцалтгүй буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хивэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнийг нөхөн сэргээхдээ аль болох анхны төрхөд нь дөхүүлэх эсвэл дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй. Харин нийгэм-эдийн засагт эерэг, буцалтгүй нөлөөллийн эрчмийг дээшлүүлэх тал дээр төсөл хэрэгжүүлэгч анхаарвал зохино.

Нөлөөллийн эрчим

Энэ төслийн хүчтэй сөрөг нөлөөлөлд ажиллагсдын эрүүл мэнд өртөж болзошгүй. Гэвч үүнийг бууруулах үүднээс ХХАА-ны журмыг сайтар баримтална. Хөрс, ургамал, газрын гадарга, эрдэс түүхий эдийн нөөц, орчны бохирдол зэрэгт дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, харин орон нутгийн нийгэм-эдийн засагт эерэг (дунд зэргийн) нөлөөлөл үзүүлэхээр байна. Нийт 27 нөлөөллөөс 1 нь хүчтэй, 15 нь дунд зэрэг, 11 нь сул нөлөөлөл бөгөөд 17 нь сөрөг, 9 нь эерэг нөлөөлөл байна.

Байгаль экосистемийн өөрчлөлт

Төслийн үйл ажиллагааны үр дагавар нь орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, ургамал, амьтад урт хугацаанд, буцалтгүйгээр, дундаас бага зэргийн эрчимтэйгээр шууд нөлөөлнө. Тухайлбал: тээвэрлэлтийн явцад хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулах нөлөө гарна. Мөн салхи ихтэй үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шороо тоос босож, агаар орчныг бохирдуулах, ойр орчны хөрс, ургамал тоосонд дарагдах, дуу чимээ, хөл хөдөлгөөнөөс амьтны амьдрах орчин багасах нөлөөлөл гарч болно. Төслийн технологи үйл ажиллагааны явцад масло, түлш зэрэг санамсаргүй асгарч, хөрс ургамалд нөлөөлөл үзүүлнэ. Хайгуулынхугацаанд хүний үйл ажиллагааны улмаас орон нутгийн иргэд, тэдгээрийн амьдрах хэв маяг, бэлчээр зэрэгт шууд болон шууд бус нөлөөлөл үүсэж болзошгүй. Хөрс элэгдэл эвдрэлд өртөж, дагтаршин ургамлан бүрхэвч хэсэг хугацаагаар устгагдаж, малын бэлчээр нутаг хумигдана. Гэхдээ төслийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны үр дүнд эдгээр нөлөөллийг нэлээд хэмжээгээр багасгах боломжтой.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт

Уг төсөл нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн төсөл учраас байгалийн баялаг нөөцийг ашиглахтай холбоотой нөлөөлөл ихтэй. Байгалийн нөөц багасах, дутуу ашиглах, сорчилж ашиглах зэрэг сөрөг нөлөөлөл гарна. Мөн газрын гадаргын нөөц болох бэлчээрт урт хугацаанд дунд эрчмээр шууд нөлөөлнө.

Байгаль орчны өөрчлөлт

Уг төсөл нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн төсөл учраас байгалийн баялаг нөөцийг ашиглахтай холбоотой нөлөөлөл ихтэй. Байгалийн нөөц багасах, дутуу ашиглах, сорчилж ашиглах зэрэг сөрөг нөлөөлөл гарна. Мөн газрын гадаргын нөөц болох бэлчээрт урт хугацаанд дунд эрчмээр шууд нөлөөлнө.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл

Төслийн орчинд ямар нэг түүх, соёлын болон археологи, палеонтологийн олдвор илрээгүй учраас сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин байгалийн өөрийн дүр төрхөд гоо үзэмжийн хувьд сөрөг нөлөөтэй.

Эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл

Уг төслийг ашиглах нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хугацаанд орлого оруулж, төсөл хэрэгжих хугацаанд болон цаашид орон нутагт ажлын байр шинээр бий болох, өрхийн орлого нэмэгдэх, ажилгүйдэл буурах, үйлдвэрлэл-үйлчилгээ тэлэх зэргээр эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Бусад нөлөөлөл

Үйлдвэрийн суурин нь байгаль орчин зохисгүй нөлөөлнө. Тухайлбал, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих, ариутгал муу, ариун цэврийн дэглэмийг сахиагүйгээс халдварт өвчин гарч болох учраас үүнээс сэргийлэх холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дээр дурдсан болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн технологийн онцлогтой холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
1	Тоосжилт	Үйлдвэрийн үйл ажиллагаа Тээвэрлэлт	Хамрах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
2	Утаа	Автомашин Ажилчдын амралтын байр Галлагаа	Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр Хадгалагдах ба тархах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
Усан орчин			
3	Хатуу болон шингэн хог хаягдал	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	Шатах тослох материал асгарснаас хөрс, хөрсний ус бохирдох Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрсний ус бохирдуулах
4	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Гүний худаг ашиглах	Гүний худгаас үйлдвэрийн хэрэглээний усыг хангаснаас нөөц багасах
Хөрсөн бүрхэвч, геологийн тогтоц			
5	Хөрсний элэгдэл,	Авто техникийн үйл ажиллагаа	Хамрах хүрээ хязгаарлагдмал Хөрсний физик, механик шинж чанар

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
	эвдрэл		өөрчлөгдөх Нөхөн сэргээлт хийснээр нөлөөллийг арилгах
6	Бохирдол	Ахуйн хог хаягдал ил задгай асгах	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана
Ургамлын нөмрөг			
7	Ургамлын талхагдал	Авто зам Барилга байгууламжуудын орчин Тоосжилт	Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргэх Тухайн орчны ургамлан нөмрөгийн төрөл зүйл багасах, хомсдох
8	Ургамлан нөмрөг устгах	Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй харьцах	Төрөл зүйл өөрчлөгдөх Устгах
Ан амьтан			
9	Хордолт	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавж үрэгдэх
10	Дайжих	Дуу чимээ Үйлдвэрийн үйл ажиллагаа	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
Нийгэм-эдийн засгийн орчин			
11	Үндсэн хөрөнгө	Татварын орлого Бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалт, орлого	Төсөвт татвар төлөх Ойролцоох оршин суугч, аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэх, амьжиргаа дээшлэх
12	Ажлын байр	Ажлын байр шинээр бий болох	Орон нутгийн иргэдээс ажилд авах Тогтмол орлогын эх үүсвэртэй болгох

Төсөл хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн нийгэм-эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх юм. Төслийг хэрэгжүүлж эхэлснээр байгаль орчныг хамгаалах, хяналт тавих зардлыг нарийвчлан тооцож, энэ ажлыг чухам хэн хариуцаж, хэзээ гүйцэтгэх зэргийг тодорхой болгох хэрэгтэй. Нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр зохиогдох байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллах нь зүйтэй.

Төслийн үйл ажиллагааны явцад орчны хөрс элэгдэл эвдрэлд орж, ургамлын бүрхүүл устгах нөхцөл үүснэ. Төслийн явцад осол аваараас сэргийлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байх шаардлагатай. Мөн энэ үеийн ахуйн хог хаягдал бохир усыг зөөх, далдлах, ариутгах, цэвэрлэх зэрэг ажлыг тодорхой шаардлагын дагуу хийнэ.

Дээрх нөлөөллийн үнэлгээнээс тооцож үзвэл, энэ төсөл байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн байдлаараа “дунд” нөлөөлөлтэй ангилалд багтаж байна. Тухайлбал, хөрс, ургамал, газрын элэгдэл, эвдрэл, газрын төрх, хотгор гүдгэрийн өөрчлөлт зэрэгт болзошгүй сөрөг нөлөөлөл нь их эрчимтэй байх ба ургамлан бүрхэвчийн нөхөн сэргээлт болон орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, орон нутгийн хөгжил зэрэгт бага болон дунд эрчмийн эерэг нөлөөлөлтэй байна.

15.2. Байгалийн аюултай үзэгдэл

Гал түймрийн аюул

Энэ орчимд гарч болох байгалийн болзошгүй осол жил бүр хавар, намрын хуурайшилтын үед гарч болох гал түймэр юм. Нөгөө талаар уулын техник болон ажилчдын тосгон өөрөө түймэр үүсгэх нөхцөл бүрдүүлж болохыг анхаарах нь зүйтэй. Гэнэтийн гал түймрийн аюулын үед ашиглах гал унтраах хэрэгслийг гүйцэтгэгч байгууллага бэлтгэх шаардлагатай.

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

- ХЖО-ын үйл ажиллагааны явцад галын аюулын үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах,

- Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэртэй тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж өөрийн ОБХТ–д (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох,
- Тус ОБХТ–г ажилчдад таниулж сургах,
- Галын аюулын эсрэг хэрэгслээр хангах (гал сөнөөгч, галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт)
- Шаардлагатай тохиолдолд галын эсрэг шинээр төхөөрөмж суурилуулж, галын хорын тоог нэмэгдүүлэх,
- Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах.

Газар чичирхийлэл

Газар хөдлөлтийн голомт үүсэж болох бүс Магнитуд (Рихтерийн шатлалаар) 7.6-8.0 газар чичирхийллийн муж (MSK-64 шатлалын баллаар) 7 баллын мужид хамаарагдана. 1000 жилд хоёр удаа газар хөдлөлтийн давтамжтай газар төслийн талбай байрласан байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших “Арвижих хүдэр” ХХК-ийн “Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр”-ийн төслийн 2024 оны БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	3320.0
2	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2000.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	820.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500.0
5	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	5000.0
6	Нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө	-
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Нийт зардал		11 640.0

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ашиглалт

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР								
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт Хорт хийн ялгарал Дуу чимээ шуугиан	Авто тээврийн хэрэгсэл зэргийг сонгоходоо шатахуун зарцуулалт багатай, ашигт үйлийн коэффициент өндөртэй технологи сонгож үзлэг оншилгоонд хамруулах	Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгсэлд	удаа	120.0	10	1200.0	2024 он	MNS 4598:2011
	Зам талбай болон бусад тоосжилт үүсч болзошгүй гадаргууг услах				Дотоод зардал		2024 он	
Нийт						-		
ГАЗАР ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ								
Олон салаа шороон зам, далангууд	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	Зам дагуу	ширхэг	1	100	100.0	2024 он	MNS 4597 : 2014
Хөрсний бүтцэд гарсан	Үйлдвэрийн ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох	Төслийн талбайд	удаа	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой				MNS 6056:2009
Хөрсний бохирдлоос хамгаалах	Үйлдвэрийн хашаанд байгаа түүхий эдийн овоолго хадгалах газрыг нар салхинаас хамгаалагдсан, хөрс бохирдохоос сэргийлсэн талбайг бий болгох	Түүхий эдийн овоолго	удаа	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой				MNS 5973:2009
Нийт						100.0		
ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Газрын доорх	Гүний худагт тоолуур тавьж засвар үйлчилгээ хийх	Гүний худаг	ширхэг	-	1	100.0	2024 он	Ус ашиглалт, хэрэглээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
усны нөөцийг бохирдох, түвшин буурах	Худгийг тоноглон хамгаалж, ундны усны гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох	Гүний худаг	удаа	600.0	1	600.0	2024 он	тоолууржуулах журам MNS OIML R 49-1:2012 Усны тоолуур хэмжилзүйн техникийн шаардлага
Нийт						700.0		
БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР								
Ан амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөлөл	Гадаад тээвэрлэлтийн зам дагуу ан амьтны нүүдэл шилжилт, ороо орох газар зэргээр өнгөрөхдөө дуут дохио ашиглахгүй байх анхааруулга хийх	Түүхий эд тээвэрлэх зам	удаа	Дотоод зардал			2024 он	MNS 4597 : 2014
	Цахилгаан дамжуулах шугам, хаягдлын сангийн ойр орчим шувуу үргээгч суурилуулах	Төслийн талбай Хаягдлын далан	ширхэг	20.0	30	600.0	2024 он	Амьтны тухай хууль
Ургамлан нөмрөг	Үйлдвэрийн хашаанд ногоон байгууламж байгуулах	Үйлдвэрийн хашаанд	удаа	Дотоод зардал			2024 он	Газрын тухай хууль MNS 6141:2010 MNS 6255 :2011 MNS 6256 :2011 MNS 6258-2:2011 MNS 6260 : 2011
	Тэрбум мод үндэний хөдөлгөөнд нэгдэж мод тарих. (Сумын БО-ны газартай хамтран тохиромжтой газар тарих)	Дархан сум	250 ширхэг	Дотоод зардал			2024 он	2021.10.04 өдрийн №58 дугаар МУ Ерөнхийлөгчийн зарилгаг“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
Нийт						600.0		
ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭМЖЭЭ								
Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах	Үйлдвэрийн ажилчид	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024 он	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажлын байранд эмийн сан бий	Ажилчдын		720.0		720.0	2024 он	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
хүний эрүүл мэндэд үүсэх сөрөг нөлөө	болгох Үйлдвэрийн ажилчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах	байр болон үйлдвэрт Үйлдвэрийн ажилчид	Иж бүрэн		-			
						Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024 он	
Нийт						720.0		
Нийт дүн						3320.0		

4.2 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн аюул гамшиг						
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	сургалт жилд 1 удаа	500.0	500.0	2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 он)
Нийт				500.0		
Галын аюул						
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах	Дүрэм, журам	Дотоод	Дотоод	2024 он	MNS5 078-2001, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага" MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244-94 □□□□ □□□□□ □□□□□□□□□□□□ ү □□□□□□□□
	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Самбар, зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээ байршуулах гал унтраах хор авах	1000.0	1000.0	2024 он	
	Гал унтраагуурын бэлэн байдал, баталгаажилт хийлгэсэн байх	Тогтмол	Дотоод	Дотоод	2024 он	

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах	Сургалт, жилд 1 удаа	500.0	500.0	2024 он	MNS 639:89 MNS 640:89 Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 γ
	Цахилгааны шитний аюулгүй байдал, газардуулгын акт, баталгаажуулалттай байх	Тогтмол	Дотоод	Дотоод	2024 он	
	Цахилгааны аюулгүйн дохиолол ажиллуулах, аюулгүйн салгууртай байх (тоног төхөөрөмж)	Тогтмол	Дотоод	Дотоод	2024 он	
	Машин механизм, тоног төхөөрөмжийг зураг төслийн дагуу угсарч суурилуулсан акттай байх (цахилгааны гэмтлээс урьдчилан сэргийлэх)	Дүрэм, журам	Дотоод	Дотоод	2024 он	
	Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байх	Тогтмол	Дотоод	Дотоод	2024 он	
	Цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны заавартай болох	Дүрэм, журам	Дотоод	Дотоод	2024 он	
	Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичиг заасан хугацаанд тогтмол хийж, техникийн ашиглалтын паспортад тэмдэглэдэг байх	Дүрэм, журам	Дотоод	Дотоод	2024 он	
Нийт				1500.0		
Нийт дүн				2000.0		

4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян.төг /	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
АХУЙН ХОГ ХАЯГДАЛ								
Ахуйн хэрэглээний хог хаягдал	Энгийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, эмх цэгцтэй хадгалах хогийн сав байршуулах.	Төслийн талбайд	ширхэг	50.0	10.0	500.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга 2017.05.12/
Буруу хадгалсан хог хаягдал түүний эх үүсвэрээс үнэрийн бохирдол гарах	Үйлдвэрийн ажилчдад зориулан хог хаягдлын ангилан ялгаж хаях талаар заавар зөвлөмж бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг байршуулах	Төслийн талбайд	ширхэг	Дотоод зардал			2024 он	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага БОАЖ-ын сайдын А/443 тушаал
	Ажилчдыг хог хаягдлыг ангилан ялгаж хаях дадал суулгах	Үйлдвэрийн ажилчдад	удаа				2024 он	
	Ахуйн шингэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг Дархан сумын БО-ний газраар гаргуулах	Төслийн талбайд	удаа				2024 он	
Нийт				500.0				
ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ								
Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	Машин техникийн үйлчилгээ, засварын тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших.	Засварын талбай	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024 он	Хог хаягдлын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам
	Үйлдвэрийн талбайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Төслийн талбай	удаа				2024 он	
	Ангилсан хог хаягдлаа дахин ашиглах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээний байгуулан нийлүүлж байх	Төслийн талбай	удаа				2024 он	
Нийт				-				
Нийт						500.0		

4.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тус төсөл нь баяжуулах үйлдвэр бөгөөд 2024 онд нөхөн сэргээлт хийхгүй болно.

4.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
Тоос нийт (PM10, PM2.5)	Баяжуулах үйлдвэр дотор-1 Үйлдвэрийн хашаан дотор-1 Хүдэрийн овоолгын ойролцоо-1 Тээврийн зам дагуу- 1цэг	Жилд 1 удаа	4 цэгт 1 удаа	50.0 төг*1удаа*4цэг	200.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага. MNS 5002:2000 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
Дуу шуугиан хэмжээ	Баяжуулах үйлдвэрийн ойр орчим-1 Тээврийн зам дагуу- 1цэг		2 цэгт 1 удаа	50.0 төг*1удаа*2цэг	100.0	
Хөрс						
Хөрсний хүнд металлууд	Баяжуулах үйлдвэрийн хашаан дотор-1 Хаягдлын далангийн ойролцоо-1 Кемп ойролцоо-1	Жилд 1 удаа	3 цэгт 1 удаа	50.0 төг*1удаа*3 цэг	150.0	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
Хөрсний эрүүл ахуй	Кемп ойролцоо-1	Жил 2 удаа Дулааны улиралд	1 цэгт 2 удаа	25.0 төг*2удаа*1 цэг	50.0	MNS 3297 : 2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Усны чанар						
Химийн найрлага	Худгийн ус (унд ахуйн ус) -1 цэг	Улиралд 1 удаа	1 цэгт 4 удаа	30.0 төг*4удаа*1цэг	120.0	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
Бичил амьсгал /Нийт нян тоо, E.col/i	Худгийн ус (унд ахуйн ус) -1	Улиралд 1 удаа	1 цэгт 1 удаа	50.0 төг*4удаа*1цэг	200.0	MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.
Нийт зардал мян. төг					820.0	

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			2	2500.0	5000.0	2024 он	БОНБУ-ний тухай хууль, ЗГ 2013 оны 374-р тогтоол Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
Нийт зардал мян. төг					5000.0		

4.7 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа хийгдэхгүй болно.

4.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	2024 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		I улирал	II улирал	III улирал	IV улирал		
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр					БО-ны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох					Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод	Дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	2024 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		I улирал	II улирал	III улирал	IV улирал		
журам тогтоож мөрдөх							
Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	Дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. /БОМТ-ний биелэлтийн тайлан/	Дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Нийт зардал мян. төг		-					

4.9 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх. Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төсөл нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр Сумын удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Аривжих хүдэр ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Хэнтий аймгийн Дархан сумын 2-р багийн иргэд, багийн дарга, сумын байгаль хамгаалагч	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулга хийх	2024 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажилласан тухай	Жил бүрийн 11 сард	-	Байгууллагын БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
Нийт зардал мян. төг				--		

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу нөлөөллийн бүсийн оршин суугчдад, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж, тайлагнах ажиллагааг зохион байгуулсан байна.